

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ  
ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ**

**4 дүгээр хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тойм №4  
2018.05.22**

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харъяа Горхи Тэрэлжийн Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Дарьгангын Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Орхоны хөндийн Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Их газрын чулууны Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Говийн дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргаа, Говийн бага дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Мөнххайрханы Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга (ахлах түшмэл ТЗ-8)-ын албан тушаалд сонгон шалгаруулалт явуулсан дүн, тухайн ажлын байрны албан тушаалд дүгнэлт гаргуулах, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>1.Чойжингийн Баярбатыг Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргааны даргын, Чойжамцын Батсүхийг Говийн бага дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны даргын, Дашдэмбэрэлийн Батмөнх, Лхагвасүрэнгийн Тулгабаатар, Мандахын Баттөр, Ганзоригтын Мөнхзул, Пүрэвврагчаагийн Баттулга, Дулаанжаргалын Ганзориг, Давгадоржийн Отгондэлгэр, Батбаярын Дайриймаа, Чантуугийн Гантогоо, Чантуугийн Гандөш нарыг Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын, Рашбудын Баттүвшинг Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын, Цэрэндагвын Бандийг Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын, Дамдинсүрэнгийн Ариунцэцэгийг Дарьгангын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын албан тушаалын нөөцийн жагсаалтад тус тус бүртгэхээр болов.</p> <p>2.Сонгон шалгаруулалтын онооны дүнгээр 1 дүгээр байр эзэлсэн Чойжингийн Баярбатыг Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргааны даргын албан тушаалд, Чойжамцын Батсүхийг Говийн бага дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны даргын албан тушаалд, Дашдэмбэрэлийн Батмөнхийг Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын албан тушаалд, Рашбудын Баттүвшинг Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын албан тушаалд, Цэрэндагвын Бандийг Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын албан тушаалд, Дамдинсүрэнгийн Ариунцэцэгийг Дарьгангын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын албан тушаалд тус тус нэр дэвшүүлж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад томилуулахаар санал болгохоор тогтов.</p> <p>3.Мөнххайрханы байгалийн цогцолборт газрын</p>

		<p>хамгаалалтын захиргааны даргын удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтад оролцсон Тавьтайн Лхагвадорж нь Манжийн Одхүүгийн боловсролын дипломыг хуурамч, ажилласан туршлага, ерөнхий шаардлагын үнэлгээнд, бичгийн болон ярилцлагын шалгалтын оноо өгсөн байдал зэрэгт гомдол гаргасан тул хянан шалгах комисс байгуулан, комиссын даргаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга В.Жавзан, гишүүдээр Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн Д.Батсайхан, Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын мэргэжилтэн Б.Дэлгэрцэцэг нарын бүрэлдхүүнтэй байгуулахаар гишүүд санал нэгтэй батлав.</p> <p>4.Мөнххайрханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын албан тушаалд өрсөлдсөн М.Одхүүгийн боловсролын дипломын хүчинтэй эсэх талаар холбогдох байгууллагуудаас лавлагаа албан ёсоор авахыг Сонгон шалгаруулах комиссын дарга Ч.Батсансар, нарийн бичгийн дарга Б.Жавзандулам нарт даалгав.</p> <p>4. Мөнххайрханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Одхүүд ажил сайжруулах 3 сарын хугацаатай үүрэг даалгавар өгч дүгнэн, дүнг танилцуулахыг Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга Ч.Батсансарт үүрэг болгов.</p>
--	--	---

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 4 дүгээр хуралдаан 2018 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 11 цаг 15 минутаас 301 тоот өрөөнд болов.

Салбар зөвлөлийн хуралдаан №4 (2018.05.22)